



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



**ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮЛЭЭЛТИЙН  
ИНДЕКСИЙН СУДАЛГАА  
(2012 оны 2-р улирал)**


## Товч агуулга

*Хэрэглэгчийн хүлээлтийн индекс (ХХИ)*

Хэрэглэгчийн хүлээлтийн индекс нь дэлхийн олонхи хөгжингүй орнуудад тухайн улс өөрийн иргэдийн хэрэглээндээ зарцуулж байгаа зардлын ирээдүйн хандлагыг тодорхойлох зорилгоор тооцдог өндөр ач холбогдол бүхий эдийн засгийн индикатор юм. Аливаа нэгэн улсын эдийн засгийн төлөв байдлыг тодорхойлоход тэргүүлэгч буюу эдийн засгийн ирээдүйн төлөв байдлыг харуулдаг индикатор болон улс орны эдийн засгийн тухайн үеийн төлөвийг харуулдаг индикаторыг тооцож үзэх шаардлагатай болдог. ХХИ нь эдийн засгийн ирээдүйн төлөв байдлыг урьдчилан харуулдаг тэргүүлэгч индикатор бөгөөд зах зээлийн эдийн засагтай орнуудын хувьд тухайн улсын эдийн засгийн ирээдүйн хандлага нь эдийн засаг дахь хэрэглэгчдийн үйл хөдлөл, эдийн засгийн ирээдүйн төлөв байдлын талаархи хүлээлт, тэдгээрийн хэрэглээндээ зарцуулж байгаа зардлын хэмжээ зэргээс голчлон хамаардаг болсон учраас дэлхийн олон улс орон хэрэглэгчдийнхээ үйл хөдлөл, хүлээлт дээр тулгуурласан энэ индексийг тооцож, шийдвэр гаргалтандаа чухал үзүүлэлт болгон ашигласаар ирсэн байна.

ХХИ нь зөвхөн бодлого боловсруулагчид, төрийн болон төрийн бус байгууллагуудын хувьд бус бизнес эрхлэгчдийн хувьд ч ирээдүйн төлөвлөлт шийдвэр гаргалтандаа ашиглаж болох мэдээллийн чухал эх үүсвэр болдогоороо ихээхэн ач холбогдолтой юм.

Ийм учраас дэлхийн хөгжингүй орнуудад энэ индекст ихээхэн ач холбогдол өгч тогтмол тооцоор ирсэн. Тухайлбал, Америкийн Conference Board, Германы ZEW зэрэг байгууллагууд энэ индексийг тогтмол тооцдог бөгөөд индекс нь эдийн засгийн ирээдүйн чиг хандлагыг гайхалтай зөв харуулж чаддаг нь батлагдсан байна.

**График 1. Америкийн Хэрэглэгчийн Хүлээлтийн индекс, ажилгүйдлийн түвшний хамаарал**

Дээрх графикт Америкийн хэрэглэгчийн хүлээлтийн индекс ба Америкийн ажил эрхлэлтийн түвшний хамаарлыг харуулжээ. Америкийн өнцөг булан бүрт амьдарч буй 500 хүнээс авдаг санал асуулга нь ажилгүйдлийн түвшний өөрчлөлтийг хэрхэн оновчтой таамаглаж байсныг графикаас тодорхой харж болно.

Манай улсын хувьд анх 2009 оноос эхлэн Санхүүгийн Зах Зээлийн Холбоо болон Нээлттэй Нийгэм Форум уг индексийг Улаанбаатар хотын хэмжээнд тус тусдаа тооцож байсан бөгөөд 2010 оны нэгдүгээр улирлаас эхлэн 2 байгууллага хамтран энэхүү индексийг тооцож байна.

*Монголын хэрэглэгчийн хүлээлтийн индексийг тооцох аргачлал*

ХХИ-ийг Монгол улсын эдийн засгийн бүтцэд тохируулан улирал тутамд нэг удаа, нийт 1000 хүнээс санал асуулга авах замаар тооцож байна. Санал асуулгад оролцогчийг Монгол улсын нийгэм, эдийн засгийн бүтцийг төлөөлөхүйц байдлаар статистик түүврийн аргаар сонгодог. Хэрэглэгчийн хүлээлтийн индексийн санал асуулга нь өөртөө Хэрэглэгчийн хүлээлтийн индекс болон индикаторыг агуулдаг. Индекс нь хэрэглэгчдийн хүлээлт өмнөх үетэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулдаг бол индикатор нь хэрэглэгчдийн эдийн засгийн талаарх ерөнхий хүлээлт эерэг эсвэл сөрөг байгаа эсэхийг харуулдаг ач холбогдолтой юм. Санал асуулга нь индекс болон индикаторыг тооцоолоход ашиглагдах таван асуулт мөн эдийн засгийн ирээдүйн төлөв байдлын талаархи хүлээлтийг тодруулах зорилго бүхий 14 нэмэлт асуултаас бүрддэг. Асуултууд нь одоогийн нөхцөл байдал ба ирээдүйн хүлээлт гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваагддаг. Түүнчлэн ХХИ нь:

- а. Хэрэглэгчдийн хэрэглээний хандлагад гарч байгаа өөрчлөлт, хүлээлт
- б. Инфляци
- в. Ажилгүйдэл
- г. Банкны секторын талаарх хэрэглэгчдийн байр суурь
- д. Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх нийгмийн байр суурь

гэсэн үндсэн 5 чиглэлээр хэрэглэгчид ирээдүйд ямар хүлээлттэй байгааг тодруулах зорилготой.

Хэрэглэгчийн хүлээлтийн индексийн судалгааг санамсаргүй түүврийн аргаар доорх эдийн засгийн 14 салбарын нийт 1000 хүнээс асуулга авч тооцдог.

- ХАА, ан агнуур, ойн аж ахуй
- Уул уурхай, олборлох үйлдвэр
- Боловсруулах үйлдвэр
- Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж
- Барилга
- Бөөний болон жижиглэн худалдаа
- Зочид буудал, зоогийн газар, ресторан
- Тээвэр, холбоо, агуулахын аж ахуй
- Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа
- Үл хөдлөх хөрөнгө, түрээс
- Төр, батлан хамгаалах
- Боловсрол
- Эрүүл мэнд, нийгмийн халамж
- Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ

2012 оны 2 дугаар улирлын ХХИ-ийн судалгааны санал асуулгыг нийт 4 бүлэг, 16 асуулттайгаар авсан.

- А хэсэг оролцогчдын ерөнхий мэдээлэл авах зорилготой бөгөөд 6 дэд асуултаас бүрдэнэ.


- Б хэсэг нь хэрэглэгчдийн ирээдүйн хандлагыг тодорхойлох зорилготой, 8 асуултаас бүрдсэн. Тус хэсгийн асуултууд, хариулт сонголтыг олон улсад хийгддэг хэрэглэгчийн хүлээлтийн талаарх түүвэр судалгаануудад өргөн хэрэглэгддэг стандарт асуултуудаас сонгон авсан болно.
- В хэсгийн асуулт хэрэглэгчдийн банк санхүүгийн байгууллагад итгэх итгэлцүүрийг тодорхойлоход зорилготой нийт 6 асуулттай.
- Харин сүүлийн Г хэсэг нь тухайн цаг үед гарч байгаа онцлог үйл явдлуудын талаар хэрэглэгчдийн санал бодлыг тодорхойлох зорилго бүхий доорхи 2 нээлттэй асуултаас бүрдсэн. Тэдгээр асуултууд нь:
  1. Сонгуульд ялсан намыг та юу хийгээсэй гэж хүсч байна?
  2. Иргэдэд олгож буй 21 мянга энэ сараар дуусгавар болж буй нь?

*Хэрэглэгчийн Хүлээлтийн Индекс 2012 оны 2-р улирал /Ерөнхий үр дүн/*

**Хэрэглэгчдийн ирээдүйн талаарх эерэг хүлээлт эрс буурсан байна.**

Хэрэглэгчийн хүлээлтийн индекс 2-р улиралд өмнөх улирлаас 11 нэгж хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 7-н нэгж хувиар буурч 192,98 болсон байна. ХХИ 2011 онд ихээхэн унасан хэдий ч энэ оны 1-р улирлаас эхлэн аажмаар өсөж буй юм.

**График 2. Хэрэглэгчийн хүлээлтийн индекс (ХХИ)**




Уул уурхай, эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор иргэд өөрсдийн амьдралыг дээшлэнэ хэмээн хүлээлт бий болсон, тэрхүү хүлээлт нь 2009 оноос эхлэн ХХИ-г огцом өсгөсөн хэдий ч 2011 оноос эхлэн инфляци, цалин зэрэгтэй холбоотойгоор эргээд огцом буурсан билээ. Гэвч 2012 оны эхнээс эхлэн ХХИ тогтвортой өссөн нь иргэдийн дунд эерэг хүлээлт бий болоод буйг харуулж байна.

Хэрэглэгчдийн өнөөгийн нөхцөл байдлын индикатор болон ирээдүйн нөхцөл байдлын индикатор өмнөх улиралтай харьцуулахад өссөн дүнтэй гарчээ.

- Өнөөгийн нөхцөл байдлын индикатор – 53,525
- Ирээдүйн нөхцөл байдлын индикатор – 68,4

Өнөөгийн нөхцөл байдлын индикатор нь хэрэглэгчид өөрийн болоод улс орны эдийн засгийн өнөөгийн төлөвийн талаар ямар бодолтой байгааг харуулдаг бол ирээдүйн төлөв байдлын индикатор нь хэрэглэгчид эдийн засгийн ирээдүйн хандлагын талаар ямар хүлээлттэй байгааг харуулдаг. Уг индикаторууд 50-иас дээш байвал одоогийн болоод ирээдүйн эдийн засгийн байдал сайн (эерэг) байгааг харуулах бол 50-иас доош байвал дээрхийн эсрэг утгыг агуулна.


**График 3. Ирээдүйн болон өнөөгийн нөхцөл байдлын индикатор**



2012 оны 2 дугаар улиралд өнөөгийн нөхцөл байдлын индикатор 50-иас дээш гарсан нь өнөөгийн эдийн засгийн байдалд хэрэглэгчдийн сэтгэлд хүрж байна гэж дүгнэхэд хүргэж байна. Харин ирээдүйн төлөв байдлын талаарх хүлээлт өмнөх улирлаас өссөн нь хүмүүсийн эдийн засгийн талаарх итгэл дахин сэргэж буйг хэлж болно.

Хэрэглэгчийн Хүлээлтийн Индекс 2012 оны 2 дугаар улирал /Дэлгэрэнгүй үр дүн/


**График 4. Судалгаанд оролцогчдийн насны бүтэц, хувиар**



Энэ удаагийн судалгаанд нийт 1000 хүн хамрагдсан. Оролцогчдын 66 хувь нь эмэгтэй, 33 хувь эрэгтэй байлаа. Энэ нь өмнөх улирлыны судалгаануудтай харьцуулахад хүйсийн харьцаа үл ялиг алдагдсан буй юм. Насны бүтцийг нь авч үзвэл 18-29 насны хүмүүс нийт оролцогчдын 44 хувийг, 30-49 насны хүмүүс 44 хувийг, 50-59 насны хүмүүс 10 хувийг, 60-аас дээш насны хүмүүс 2 хувийг тус тус эзэлж байна. Эндээс харахад манай судалгаанд 18-49 насныхан нийт судалгаанд оролцогчдын 88 хувийг бүрдүүлсэн нь хүн амын насны бүтцийн харьцааг илэрхийлж байгааг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын өрхийн сарын орлогын хэмжээг авч үзэхэд нийт судалгаанд хамрагдсан хүмүүсийн 1,65 хувийг 100'000 төгрөгөөс бага, 13,71 хувийг 100'000-300'000 төгрөгийн, 36,6 хувийг 300'000-500'000 төгрөгийн, 26,39 хувийг 500'000-800'000 төгрөгийн, 21,65 хувийг 800'000 төгрөгөөс дээш орлоготой хүмүүс тус тус эзэлсэн байна.

**График 5. Өрхийн орлого**




Дээрхи графикаас харахад санал асуулгад оролцогчдын 85 хувь нь сарын 300 мянган төгрөгөөс дээш орлоготой байгаа бөгөөд энэ нь улирал бүрд өссөн дүнтэй гарч байгаа нь иргэдийн орлого нэмэгдсээр байгааг харуулж байна.

Өрхийн ам бүлийн тоо нь 3.4 буюу нэг өрх дунджаар 3 хүнтэй байна. Нийт судалгаанд оролцогчдын боловсролын түвшин өмнөх улиралтай харьцуулах дээд боловсролтой хүний хувьд 12 нэгжээр өсөж 66,8 хувь, бүрэн дунд боловсролтой хүн 27,2 хувь, анхан болон бусад боловсролтой хүн 6 хувь байсан байна. Эндээс харахад дээд боловсролтой хүн нилээдгүй өссөн байгаа юм.

**Эдийн засгийн голлох үзүүлэлтүүд болох үнийн өөрчлөлт, ажил эрхлэлтийн талаар судалгаанд оролцогчид дараах хариултыг өгсөн байна.**

1. Сүүлийн нэг жилийн турш танай гэр бүлийн санхүүгийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөн бэ? гэсэн асуултанд санал асуулгад оролцогчдын дийлэнх буюу 51 хувь нь ижил түвшинд буюу өөрчлөгдөөгүй гэж хариулсан байхад 33 хувь нь өөрийн өрхийн орлогыг өссөн, 16 хувь нь муудсан гэж хариулсан байна. Өмнөх улирлуудаас санхүүгийн нөхцөл байдал муудсан гэсэн хариулт 3 нэгжээр буурсан нь иргэдийн санхүүгийн чадвар сайжирч байгааг харуулж байна.

**График 6. Сүүлийн нэг жилд гэр бүлийн тань санхүүгийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөн бэ**




**График 7. Нэг жилийн дараа гэр бүлийн тань санхүүгийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөнө гэж бодож байна вэ**




2. Таны бодлоор ирэх нэг жилийн хугацаанд манай орны эдийн засгийн нөхцөл байдал өнөөдөртэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдөх бол?, мөн Та ирэх гурван жилийн хугацаанд манай орны эдийн засаг тогтвортой цаашид өснө гэж бодож байна уу эсвэл ямар нэгэн хямралд орж болзошгүй гэж бодож байна уу?

**График 8. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад өнөөгийн улс орны эдийн засгийн нөхцөл байдлыг та хэрхэн дүгнэж байна вэ**




3. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өнөөгийн манай орны эдийн засгийн нөхцөл байдлыг та хэрхэн дүгнэж байна вэ? гэсэн асуултанд нийт судалгаанд оролцогчдын 31 хувь нь улс орны эдийн засаг муудсан гэж үзсэн байгаа нь өмнөх улирлуудтай харьцуулахад эрс багассан байна.

**График 9. Ирэх 1 жилийн хугацаанд манай орны эдийн засгийн нөхцөл байдал өнөөдөртэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдөх бол**



4. Ирэх 1 жилийн хугацаанд манай орны эдийн засгийн нөхцөл байдал өнөөдөртэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдөх бол

**График 10. Та ирэх 3 жилийн хугацаанд манай орны эдийн засаг тогтвортой өснө гэж бодож байна уу эсвэл ямар нэгэн хямралд орж болзошгүй гэж бодож байна.**




5. Та ирэх 3 жилийн хугацаанд манай орны эдийн засаг тогтвортой өснө гэж бодож байна уу эсвэл ямар нэгэн хямралд орж болзошгүй гэж бодож байна.

гэсэн шууд хүлээлтийг илтгэх асуултуудад оролцогчдын тус тус 15, 21 хувь нь буурна болон муудна гэсэн хариулт өгсөн байна.

Инфляцийн хүлээлттэй холбоотой 6. *Танай гэр бүлийн өдөр тутмын хэрэглэдэг бараа бүтээгдэхүүний үнэ сүүлийн нэг жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн бэ?* асуулгад оролцогчдын 87 хувь нь үнэ өссөн гэж хариулсан байна. Харин 7. *Таны бодлоор өнөөдөр ямар нэгэн сарын орлогоос тань давсан томоохон эд зүйлс /тавилга, үл хөдлөх хөрөнгө г.м/ худалдан авахад тохиромжтой үе мөн үү?* асуултад оролцогчдын 52 хувь тохиромжгүй буюу мэдэхгүй хэмээн хариулжээ. Энэ нь нэг талаас иргэдийн дунд инфляциас болгоомжлох хүлээлт өндөр байх магадлалтайг илтгэх боловч, мөн үнийн өсөлтөөс өрсөж томоохон худалдан авалт хийх бодолгүй байгаа нь иргэдийн болгоомжлол өргөн хэрэглээний барааны өсөлтөөс илүүтэй үүдэлтэй гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг тодруулах зорилгоор асуусан асуултанд санал асуулгад оролцогчдын хувь нь ирэх нэг жилийн хугацаанд ажлын байраа солих бодолгүй байгаа бөгөөд 78 хувь нь энэ ажлын байраа цаашид тогтвортой байна гэж хариулсан байна. Энэ нь өмнөх улирлаас бага зэрэг бууралттай гарсан ч ойрын хугацаанд хөдөлмөрийн зах зээл дээр ихээхэн шилжилт хөдөлгөөн гарахгүй болохыг илэрхийлж байна.

**График 11. Хөдөлмөр эрхлэлтийн байдал**





Хэрэглэгчдийн банк санхүүгийн байгууллагуудад итгэх итгэлийг тодорхойлох зорилготой 3 дугаар бүлгийн асуултуудад нийт харицлагчидын 35 хувь нь Монголын банкууд найдвартай гэж хариулсан ба 13 хувь нь найдваргүй гэсэн хариулжээ. Харин санал асуулгад оролцогчдын 52 хувь нь энэ талаар сайн мэдэхгүй байна гэжээ. Үүнээс үзвэл банкуудын үйл ажиллагаанд итгэх итгэл ихсэж буй юм.Ы

9. Хадгаламжаа хэрхэн байршуулах нь зохистой вэ? мөн Хуримтлалаа хэрхэн байршуулсан бэ? гэсэн асуултад санал асуулгад оролцогчид дараах байдлаар хариулсан байна.

**График 12. Хүмүүс мөнгөн хөрөнгөө хэрхэн байршуулбал зохистой вэ**





График 12-оос харахад дийлэнх буюу 50 хувь нь үл хөдлөх хөрөнгөнд байршуулбал зохистой гэж үзсэн нь цаашид үл хөдлөх хөрөнгө үнэ цэнээ хадгална, эсвэл үнэ өснө гэсэн хүлээлт байгаа нь харагдаж байна. Үнэт цаасанд байршуулбал зохистой гэсэн хариулт 12,6 хувь буюу өмнөх улиралтай төстэй байгаа нь уул уурхайн ордуудыг ашиглалтанд оруулах, иргэдэд хувьцаа тараах зэрэг үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгийн зах зээлийг сонирхох сонирхол хэвээр байгааг харуулж байна. Харин хуримтлалаа одоо хэрхэн байршуулсан тухайгаа доорхи байдлаар хариулсан байна.

**График 13. Хуримтлалаа хэрхэн байршуулсан бэ?**



Нийт судалгаанд оролцсон хүмүүсийн 58 хувь нь банкинд төгрөгөөр байршуулсан нь төгрөгийн тогтвортой байдалд итгэлтэй байгааг харуулж байна. Харин График 12-т харуулснаар 37 хувь нь л банкинд байршуулбал зохистой гэж үзэж байсан хэдий ч бодит байдал дээр 74 хувь нь банкинд мөнгөө байршуулсан байгаа нь хуримтлалаа байршуулах өөр арга зам, боломжийн талаар мэдлэг сул байгааг харуулж байна. Мөн судалгаанд оролцогчдын 17 хувь нь үнэт цаасанд хуримтлалаа байршуулсан байгаа нь хөрөнгийн зах зээл хөгжиж буйг харуулж байна.

Түүнчлэн уг судалгаанд оролцогчдоос банкны зээлтэй эсэх мөн манай улсад зээлээр бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд хэр хүндрэлтэй байдаг болохыг тодруулах зорилгоор асуусан асуултанд өмнөх улирлаас бага зэрэг багасаж буюу 41 хувь нь зээлтэй гэж хариулсан бөгөөд харин манай улсад зээлээр бизнесийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл учирч байгаа гэж хариулсан оролцогчид 58 хувь болсон байна. Энэ нь Монгол банк бодлогын хүүгээ нэмснээр иргэдэд дарамт учруулж байгааг харуулж байна.

### *Дүгнэлт*

Хэдийгээр иргэдийн орлого өссөн хэдий ч хэрэглээний барааны үнэ нэмэгдсэнээс 2012 оны 2 дугаар улирлын хэрэглэгчийн хүлээлтийн индекс өмнөх улирлаас ихэссэн үр дүн гарч хэрэглэгчдийн эерэг хүлээлт бий болж байна. Иргэд өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдалд дассан болоод ч тэрүү илүү эерэгээр хүлээж авах болжээ.

Мөн хүмүүс ажилдаа тогтвортой байх хандлагатай байгаа бөгөөд хөдөлмөрийн зах зээл дээр ихээхэн шилжилт хөдөлгөөн гарахгүй байхаар байна.

Хэрэглээний барааны үнийн өсөлтөөс хамаараад хэрэглэгчдийн дунд болгоомжлол үүсч, үл хөдлөх хөрөнгө худалдан авах сонирхол буурсанч мөнгөн хөрөнгөө байршуулах хамгийн оновчтой арга гэж үзсээр байна. Тиймээс үл хөдлөх хөрөнгийн үнэ хадгалагдаж, буурахгүй гэсэн дүгнэлт гаргаж болохоор байна.

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад манай улсын нийт ард иргэдийн хүлээлт харьцангуй ихсэж, ирээдүйгээ илүү гэгээлэг байдлаар төсөөлж эхэлж буй нь харагдаж байна. ыы